



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

“Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/460 дугаар захирамж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2022 оны дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулж, аялагч, амрагчдад аяллын талаарх мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг 2022 оны 05 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Мишээл Экспо ОУУХТ-д зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 20 000 000 /хорин сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй.


4. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА *D. Batim* Д.БАТСҮХ



1150500052

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 14 сарын 15 өдрийн
А/13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО-2022” ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Туул	Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
	М.Мөнхжаргал	Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-ын Ерөнхий менежер /зөвшилцсөнөөр/
	Т.Туул	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
	Б.Баярцэнгэл	Мэдээллийн төвүүд хариуцсан ажилтан
	Б.Ишдорж	Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Б.Жаргалан	Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 05 өдрийн
А/С дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО-2022” ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Талбайн тохижилтын зардал /тайз/	Багц	5 000 000	5 000 000
2	Хөтлөгчийн зардал	Хүн/өдөр 1/3	500 000	1 500 000
3	Маркетинг, сурталчилгаа /шторк, контент/	Багц	5 250 000	5 250 000
4	Хөтөч сэтгүүл хэвлэх	1500 ш	5 500	8 250 000
Нийт дүн				20 000 000

--- оОо ---